



“ДАМБАДАРЖАА ДУЛААНЫ СТАНЦ БАРИХ” ТӨСӨЛ”-ИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР:0004103 /

АГУУЛГА

1	ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	1
1.1	Ерөнхий мэдээлэл	1
1.1.1	Төслийн товч танилцуулга	7
2	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ	8
3	БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГАА	9
3.1	Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл	9
3.1.1	Уур амьсгал.....	10
3.1.2	Агаарын чанар	11
3.1.3	Гадаргын ус.....	11
3.1.4	Газрын доорхи ус.....	12
3.1.5	Хөрсөн бүрхэвч.....	13
3.1.6	Ургамлан нөмрөг	14
3.1.7	Ан амьтан.....	14
3.1.8	Түүх соёлын өв	14
3.1.9	Тусгай хамгаалалттай газар нутаг.....	14
4	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	15
5	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЦ БҮРЭЛДЭХҮҮН, НИЙТ ЗАРДАЛ	16
6	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
6.1	ДАНР гэрээний дугаар бүхий Дамбадаржаа дулааны станц багцад 2025 онд хийгдэх ажил.....	17
7	НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	28
7.1.1	ДАНР гэрээний дугаартай Дулааны станц барих талбайн техникийн нөхөн сэргээлтийн зардлын тооцоо.	28
8	БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	29
9	НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ	29
10	ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	30
11	ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	31
12	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	35

13	ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР (ОХШХ).....	37
14	БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ.....	39
15	УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ, ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ.....	40

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 4-1	Байгаль орчны бүрэлдэхүүнд тус бүрд үзүүлж болзошгүй нөлөөлөл.....	15
Хүснэгт 5-1.	Дамбадаржаа дулааны станц барих төслийн 2025 БОМТ-ний зардлын хураангуй.....	16
Хүснэгт 6-1.	ДАНР багцын 2025 онд хэрэгжүүлэх Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	17
Хүснэгт 7-1.	Нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ.....	28
Хүснэгт 9-1.	Газар эзэмшлийн нөхцөл байдал.....	29
Хүснэгт 10-1	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	30
Хүснэгт 13-1.	Лабораторийн шинжилгээний тариф.....	37
Хүснэгт 14-1	. БОМТ хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь.....	39
Хүснэгт 15-1.	Удирдлага зохион байгуулалт, оролцогч талуудад мэдээлэл өгөх, тайлагнах, хэлэлцүүлэх арга хэмжээ.....	40

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1-1.	Төслийн байршил.....	Error! Bookmark not defined.
Зураг 1-2.	Дамбадаржаа дулааны станц.....	3
Зураг 3-1.	Төсөл хэрэгжих орчны өнөөгийн байдал.....	9



1 ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Ерөнхий мэдээлэл

Төслийн нэр

“Дамбадаржаа дулааны станц барих төсөл”

Төслийн дугаар: 2021/Е33,

БОНЕҮД-ийн дугаар: 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 13/1773 тоот дүгнэлт

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн нэгж”

Регистрийн дугаар: 0004103

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Сүхбаатарын талбай -11


Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн нэгжийн зохицуулагч : Д.Авирмэд

Холбоо барих утас: 976-9911-8303, 7000-3099

Төслийн барилга барих аж ахуй нэгж

China Second Metallurgy Group LLC


Зураг 1-1. Төслийн байршил






Зураг 1-2. Дамбадаржаа дулааны станц

Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр, 2 дугаар үе шат





1.1.1 Төслийн товч танилцуулга

Азийн Хөгжлийн Банк болон НЗДТГ хамтран санхүүжүүлэн хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл 3 үе шаттай нийт 9 жилийн хугацаанд хэрэгжинэ. Уг хөтөлбөр төслийн хүрээнд 6 дэд төвийн ажлын хүрээнд 28 МВт, 50 МВт, 58 МВт хүчин чадалтай нийт дулааны 3 станцбарина. Үүнд: Сэлбэ, Дамбадаржаа болон Дэнжийн мянга дэд төвүүдэд тус бүр нэг дулааны станц төлөвлөсөн. Одоогоор Сэлбэ дэд төвд 28 МВт хүчин чадалтай 3 зуух бүхий дулааны станц нь ашиглалтад орсон.

Төлөвлөгдөж буй Дамбадаржаа дулааны станц нь Чингэлтэй дүүргийн 19-р хорооны нутаг дэвсгэрт буюу гэр хорооллыг хөгжүүлэх төслийн хүрээнд төлөвлөлт хийгдэж буй Дамбадаржаа дэд төвөөс баруун урагш тийш 500 метрийн зайд, Сэлбийн гүүрнээс баруун зүгт 318 метрийн зайд байрлана. Дулааны станцын төлөвлөлтийн нийт талбайн хэмжээ 24,000 м² буюу 2.4 га байх бөгөөд үүнээс барилгажих талбайн хэмжээ 8595 м² байна.

Дамбадаржаа дулааны станц нь 63 МВт хүчин чадалтай, дулааны төв шугам 6.8 хос км урт, таслах хаалт 132 ш, компенсатор 122 ш, жилд 181,980 Гкал дулаан түгээж, 64,907 тонн нүүрс зарцуулна. Тус станц нь нутгийн хөгжлийн чанартай, улсаас санхүүжилттэй байх тул дулааны станц сүлжээг барьж дууссаны дараа орон нутгийн өмчит юм уу төрийн өмчит компани байгуулж удирдлага зохион байгуулалтыг шийдэх боломжтой. Орон тооны хувьд дулааны станц болон дулааны шугам сүлжээний удирдлага, инженер техникийн ажилтан, ашиглалт, засварын ажилчид нийтдээ 110 ажилтан байхаар төлөвлөсөн байна.

Дамбадаржаа дулааны станцын барилгын ажлыг 2024 оны 09 сард эхлүүлсэн бөгөөд ажилчдын кемп, хоолны газар болон ариун цэврийн байгууламж баригдаж дууссан. Одоо суурийн цутгалтын бэлтгэл ажлууд хийгдэж байна. Туслан гүйцэтгэгч компанийн үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдан зохион байгуулах асуудлыг хариуцан ажиллуулахаар 2024 оны 07 сарын 17-ны өдрийн 9941606 дугаартай хамтран ажиллах гэрээг ХАБЭА чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Сейфти Грийн Зон” ХХК-тай байгуулсан байна. 2024 оны 08 сарын 14-ны өдрийн А/64 дугаартай Туул голын сав газрын захиргааны даргын тушаалаар “China second metallurgy group” ХХК-д Ус шавхан зайлуулах зөвшөөрөл олгосон байна. 2024 оны 07 сарын 17-ны өдөр №ХУЗ-24/0717-01 дугаартай Хөрсний ус шавхан зайлуулах ажил гүйцэтгэх гэрээг “Канда” ХХК-тай байгуулж, гэрээний дагуу хөрсний усыг шавхан зайлуулж байна. Чингэлтэй дүүргийн 19-р хорооны Засаг Даргатай хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хураан төвлөрүүлэх гэрээ байгуулж энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлүүлж байна.

Одоогоор төслийн талбайд инженер, техникийн ажилчид нийт 12 хүн ажиллаж, гэрээт компаниас барилгын ажлын аюулгүй ажиллагаа, ХАБЭА асуудлыг хариуцсан 3 хүн байна.

2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү төлөвлөгөөний зорилго нь 2025 онд явагдах барилгын ажлын үед байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, ерөнхий үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд үр дүнтэй байгаа эсэхийг тогтооход оршино. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө, Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө, Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө, Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр, БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь зэргээс бүрдэнэ.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль Орчин Аялал Жуулчлалын Сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-д заагдсан бүтэц, агуулга, аргачлалын дагуу боловсруулав.

Дамбадаржаа дулааны станц барихаар төлөвлөлт хийгдсэн газар нь нийт 2.4 га талбайг хамрах ба засаг захиргааны хил хязгаарын хувьд Чингэлтэй дүүргийн 19 -р хороонд хамаарна.

3 БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГАА

3.1 Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл

Улаанбаатар хот, түүний орчмын нутаг дэвсгэр нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Хэнтийн уулархаг мужийн баруун урд үзүүрт Туул голын хөндийн 2.5-4 км хүртэл өргөсч тохойрсон татам болон дэнжийн хэсэгт байрладаг. Газарзүйн байршлын хувьд ойт хээрийн бүсэд багтдаг бөгөөд 1950-2268 м үнэмлэхүй өндөртэй Богдхан, Чингэлтэй Хайрхан зэрэг уулсаар хүрээлэгдэнэ.

Зураг 3-1. Төсөл хэрэгжих орчны өнөөгийн байдал



Төсөл хэрэгжих талбай нь тэгш гадаргатай бөгөөд газрын налуу, хэвгий харьцангуй багатай цэгт сонгогдсон бөгөөд олон арван жилийн туршид гэр хорооллын суурьшлын бүс байсан тул гадаргын эвдрэл, элэгдлийн эрчим өндөртэй бүсэд тооцогдоно.

Газрын гадарга: Дамбадаржаа дулааны станц нь Улаанбаатар хотын хойд хэсэг нь 1800 м өндөр бүхий Чингэлтэйн салбар уулсын зүүн талд, баруун зүүн Сэлбэ голын уулзварт байрлана. Чингэлтэйн салбар уулс нь харьцангуй мөлгөр оройтой бөгөөд өвөр хажуу нь аажим намссаар Мааньт, Тасганы овооны толгодорхог гадаргууд шилжиж үнэмлэхүй өндөр нь багасаж улмаар Туул голын хөндийн хэсэгт тулж очдог байна. Дээрх өндөр уулсын муж болон уулс хоорондын тэвш маягийн хөндлөн огтлолтой суумал хөндийн газрын гадаргуугийн харьцангуй өндөршлийн зөрүү ихэвчлэн 400-500 м боловч заримдаа 700-920

м хүрч байна. Эдгээр өндөр уулсын мужийн хажуу ташлаг, энгэр бэлийн налуу нь ихэвчлэн 15-20 хэм, зарим тохиолдолд 30-35 хэм хүртэл ихэсдэг. Сэлбэ голын хөндий нь хотгор гүдгэрийн хувьд тэгшрэлийн гадарга бүхий нэгэн хөндийн системийг үүсгэх боловч гадаад хүчний нөлөөгөөр өөрчлөгдөн хувирсаар хэд хэдэн ширээ өндөрлөг болон гол, горхи ам хөндийгөөр ихээхэн хэрчигджээ. Газрын гадаргуугийн налуу нь 8%-иас бага буюу харьцангуй налуу багатайд тооцогдох тул хот суурин газрын төлөвлөлт хийж хөгжүүлэхэд таатай орчныг бүрэлдүүлж байгаа юм.

Байгалийн бүс, бүслүүр: Дархан цаазат Богдхан уул нь Хэнтийн нурууны уулархаг мужийн баруун өмнөд захад орших боловч өндрийн нөлөөгөөр ой, тайгын ландшафт голлох байр эзэлдэг. Богдхан уул нь манай орны зүүн хэсэг дэхь ойн тархалтын хамгийн урд хэсэг болдог бөгөөд зүүн өмнөд ба өмнөд хэсгээрээ хуурай хээрийн ландшафттай залгадаг тул ургамал, амьтны зүйлийн тархалтын хувьд ихээхэн өвөрмөц юм. Амьтны газарзүйн мужлалын хувьд умардын их мужийн хөвч тайгын дэд муж, Хэнтийн тойрогт багтана.

3.1.1 Уур амьсгал

Улаанбаатар хот нь ойт хээрийн бүсэд далайн түвшнээс дээш 1950-2265 м өндөртэй Богд-Хан, Сонгино-Хайрхан, Чингэлтэй, Баянзүрх уулын дунд Туул голын хөндийд байрладаг (Даваадорж. Д, 2020). Ерөнхийдөө өвөл нь удаан (цас их унана), зун нь богино (аагим халуун, хур тунадас ахиухан ордог ч үе үе цочир хүйтрэн сэрүүсдэг), хавар, намар хүчтэй шуургатай өдөр тохиолддог.

Бид Улаанбаатар хотын уур амьсгалыг тодорхойлохдоо далайн түвшнээс дээш 1300 м орших “Улаанбаатар” цаг уурын станцын 1969-2019 оны хоорондох олон жилийн агаарын температур, хур тунадас, салхины хурд гэсэн статистик үзүүлэлтүүдийг ашиглалаа.

Улаанбаатар станцын дулаан, хүйтний горимыг авч үзэхэд жилийн дундаж агаарын температур -0.3°C байгаа нь агаарын температурын хувьд сэрүүвтэр ойт хээрийн бүсэд хамаарагдах бөгөөд өвлийн улиралд -21°C , зуны улиралд $+19.3^{\circ}\text{C}$ -ийн хооронд хэлбэлзэнэ. Агаарын температурын жилийн амплитуд дунджаар 23.7°C орчим байна.

Агаарт цочир хүйтрэх анхны дундаж хугацаа 9 дүгээр сарын 3-р арав хоногт байх ба хамгийн эрт нь 9 дүгээр сарын 1-р 10 хоногт байна. Харин эцсийн хүйтрэлт дунджаар 6 дугаар сарын эхний 10 хоногт, хамгийн хожуу нь 6 дугаар сарын 2-р 10 хоногт тохиолдож, цочир хүйтрэлтгүй үеийн үргэлжлэх хугацаа дунджаар 137 хоног байна..

3.1.2 Агаарын чанар

Дамбадаржаа дулааны станц нь Улаанбаатар хотын агаарын бохирдол ихтэй, гэр хорооллын нягтрал өндөртэй бүсэд байрлах бөгөөд баруун талаас Чингэлтэй ам, зүүн талаас Бэлх-Сэлхийн ам, урд талд Сэлбэ дэд төв гэсэн томоохон гэр хорооллын суурьшлын бүс дэхь олон мянган жижиг хэмжээний бохирдуулагч эх үүсвэрийн нөлөөгөөр зундаа тоосжилт, өвөлдөө нүүрстөрөгч, хүхрийн давхар исэл, азотын давхар исэл зэрэг бохирдуулагч бодис орчны агаарт тархаж, агаарын бохирдлын эх үүсвэр болдог байна. Төслийн талбай орчмын бүс нутгийн агаарын чанарын төлөв байдлыг тодорхойлох зорилгоор тодорхойлох зорилгоор Байгаль орчны төв лабораторийн шинжээч Д.Сувд төслийн талбайд хүхэрлэг давхар исэл, бага ширхэгтэй тоосны агууламж, азотын давхар исэл зэрэг бохирдуулагч бодисын хэмжилтийг 2020 оны 08-р сарын 24-ний өдөр хийж гүйцэтгэсэн. Үүнээс гадна, төсөл хэрэгжих талбайд хамгийн ойр буюу газрын Сүхбаатар дүүрэг 16- р хороо Уул уурхайн хүрээлэнгийн хашаанд байрлах Ус цаг уур, орчны шинжилгээний УБ-9 агаарын чанарын хяналтын станцын сүүлийн 5 жилийн мэдээг авч үзлээ. 2014-2019 онд Улаанбаатар хотын агаарын чанарын төлөвийг тодорхойлох хяналтын цэгүүдэд хийсэн агаар дахь бохирдуулах бодисын жилийн дундаж агууламжийг Агаарын чанарын MNS 4585:2025 стандарт /АЧС гэх/ дахь хүлцэх хэм хэмжээ /XXX/-тэй харьцуулахад хүхэрлэг хийн агууламж 22 мкг/м³-д хүрч 2.2 дахин, том ширхэглэгт тоосонцорын агууламж 195 мкг/м³-д хүрч 3.9 дахин, нарийн ширхэглэгт тоосонцорын агууламж 72 мкг/м³-д хүрч 2.9 дахин, азотын давхар ислийн агууламж 59 мкг/м³-д хүрч 2.0 дахин тус тус их байсан байна.

3.1.3 Гадаргын ус

Дамбадаржаа дулааны станц нь Сэлбэ голын хөндийд орших бөгөөд төсөл хэрэгжих орчны гадаргын усан сүлжээ нь Сэлбэ голын баруун ба зүүн салаа, тэдгээрт нийлэх үерийн урсацын сувгуудаас бүрдэнэ. Сэлбэ гол нь Бага Хэнтий нурууны баруун урд хажуугийн салбар бэсрэг уулс болох Их Баян уулын (2033 м) ба Цохиот уулын (1706 м) завсараас эх авах ба Их баян ба Багабаян голуудын уулзвараас Сэлбэ нэртэй болж, Туул голд Улаанбаатар хотын Дулааны 4 дүгээр цахилгаан станц орчмоор цутгана. Голын дагуу Хандгайт, Шарга морьт, Яргайт, Бэлх зэрэг жижиг гол горхи, булгууд болон хур бороо элбэгтэй үед хоёр хажуугийн уулсаас хуурай сайрууд усжиж Сэлбэ голыг тэжээнэ.

Сэлбэ голын олон жилийн дундаж урсац нь ажиглалт хэмжилтийн дүнгээс үзэхэд Сэлбэ-Санзай харуулын орчимд 0.24 м³/сек, Сэлбэ-Дамбадаржаа харуулын орчимд 0.65 м³/сек тус тус байдаг.

Сэлбэ голын нийт урт ойролцоогоор 30 орчим км бөгөөд ус хурах талбай нь ойролцоогоор 300 км² гаруй болно. Голын урсацын 15-40%-ийг ул хөрсний ус эзлэх ба ус хурах талбайн усны хагалбарт ойртох тутам багасаж, голын адгаар нэмэгдэх зүй тогтолтой. Сэлбэ голын усны үндсэн тэжээл нь зун намрын хур бороо байдаг тул усны түвшин нь ихээхэн тогтворгүй болно. 4 дүгээр сарын сүүлч, 5 дугаар сарын эхээр хаврын шар усны үер ажиглагдах боловч хугацаа урсацын хэмжээний хувьд бага болно. Гэхдээ өмнөх жилийн услаг, хүйтний улирлын тунадас зэргээс шалтгаалан шар усны үер хугацааны хувьд эрт хожуу болон хэмжээний хувьд зуны хур борооны үерийг давах тохиолдол бий. Сэлбэ голын савын бүсэд шар усны үер жилийн нийт урсацын 10-12%-ийг эзэлнэ. Сэлбэ гол нь гол мөрний горимын ангиллын хувьд хаврын шар усны ба дулааны улирлын хур борооны үертэй голд хамрагдана.

3.1.4 Газрын доорхи ус

Дамбадаржаа дулааны станц орчим нь гидрогеологийн давхрага зүйчлэлийн хувьд дараах уст үе давхарга, цогцолбор, газрын доорх усны бусад хуримтлал, бөөгнөрлийг ялгаж байна. Үүнд:

- Голоцены үеийн аллювийн гарал үүсэлтэй сэвсгэр хурдасны уст давхарга (alQ₂)
- Дунд-дээд плейстоцений үеийн делюви-пролювийн гарал үүсэлтэй сэвсгэр хурдасны уст давхарга (dpQ₁₋₂)
- Доод-дунд карбоны настай тунамал-хувирмал чулуулгийн зузаалаг дахь уст цогцолбор (C₁₋₂) зэрэг болно.

Голоцены үеийн аллювийн гарал үүсэлтэй сэвсгэр хурдасны уст давхарга нь Сэлбэ голын хөндийн татмын нарийн зурвас бүсэд түгээмэл тархсан. Дээрх насны сэвсгэр хурдасны уст үе давхаргын геологийн зүсэлтийн литологийн бүрэлдэхүүнд 1.5-3.0 м-ээс 7.0-16.0 м хүртэлх гүнд ихэвчлэн хөх саарал өнгийн элс, элсэнцэрээр дүүргэгдсэн 10.0-30.0 см голчтой бул чулуу, сайтар ангилагдсан хас, цахиржсан элсжин, зануужингийн хайрга, хайрганцар зонхилдог. Голын хөндийн татмын хэсэгт аллювийн гарал үүсэлтэй орчин үеийн сэвсгэр хурдасны дотор өрөмдсөн гидрогеологийн цооног болон ашиглалтын худгийн ундарга 12.2- 43.8 л/с бөгөөд богино хугацааны шавхалт ба ашиглалтын үед усны түвшний бууралтын хэмжээ 1.05 -1.22 м, заримдаа ховроор (тэжээлийн гачиг үе болох жил бүрийн 2-4 сард) 7.0-10.0 м хүрдэг. Уст үе давхаргын ус өгөмж 0.1-0.15 ба шүүрэлтийн итгэлцүүр 39.96 – 207.6 м/хоног, ус дамжуулах чадварын итгэлцүүр 655.35- 3633.6 м²/хоног байна. Тухайн уст үе давхаргын газрын доорх ус химийн найрлагаараа голчлон кальци-натри, гидрокарбонатын ангид багтдаг ба эрдэсжилт нь байгалийн горимийн нөхцөлд 56.0 -150.0 мг/л, ерөнхий хатуулаг 0.50 – 0.80, заримдаа 1.5- 2.5 мг- экв/л байна.

Сэлбийн голын хөндийн ай савын хэмжээнд Ногоон нуур, нийслэлийн 3 дугаар дунд сургууль, хүүхдийн хуучин II эмнэлэг орчмоос хойшоогоо голын хөндийг өгсөөд Дамбадаржаагийн хийд хүртэлх 6.0 км урт бөгөөд дунджаар 1.2 км заримдаа 1.5 км өргөнтэй зурвас талбайд ялангуяа Сэлбэ, Бэлхийн голуудын бэлчирийн хоорондох 1.0x10 км² хэмжээтэй нилээд өргөссөн бүсэд голын гарал үүсэлтэй дөрөвдөгчийн элс, хайргархаг сэвсгэр хурдсанд газрын доорх усны байгалийн тодорхой нөөц баялаг хуримтлагдан бий болсон байна.

Харин Дамбадаржаагийн хийд болон бэлчир орчмоос дээш Сэлбийн голын ай савын хөндийг өгсөөд 3.5 км урттай 0.8-1.0 км өргөн ба Бэлхийн голын бэсрэг хөндийн дагуу 5.0 км урт сунасан 0.4-0.5 км өргөнтэй зурвас татмын хэсэгт дөрөвдөгчийн сэвсгэр хурдасны газрын доорх усны зохих хэмжээний бөөгнөрөл, хуримтлал үүсэж бий болох өндөр магадлалтай байна.

3.1.5 Хөрсөн бүрхэвч

Төсөл хэрэгжих Дамбадаржаа дулааны станц нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн өндрийн бүсшилийн Хэнтийн мужийн Хэнтийн баруун хэсгийн 39-р тойргийн (Үндэсний атлас, 2009) нутгийг хамран байрлах бөгөөд хотжилт, гэр хорооллын нөлөөгөөр *Хот суурингийн эвдэрсэн хөрс* болон өөрчлөгдсөн байна (“Монгол орны хөрсний дижитал зураглал, хөрсний шинэчилсэн ангилал” сэдэвт ажлын тайлан, 2014).

Дамбадаржаа орчмын Билгэхийн голын хөндий хэсгээр аллювийн ширэгт бараан хөрс болон аллювийн сайргархаг хөрсүүд бүрдэл байдлаар тархдаг байсан ба сүүлийн жилүүдийн хүн амын төвлөрөл, гэр хороололын айл өрхүүд нэмэгдсэний нөлөөгөөр хөрсөн бүрхэвч эвдрэл, доройтолд орж байгалийн унаган төрхөө бүрмөсөн алдсан тул хөрсний шинэчилсэн ангиллаар *Хот суурингийн эвдэрсэн хөрсний ангилалд багтах* болсон. Одоогийн байгаа хот суурингийн эвдэрсэн хөрс нь ялзмагт үе давхаргагүй болж зулгарсан, ургамалгүй, халцгай байх ба хөрсний дээжийг өнгөн үеийн 0-10 см гүнээс авсан.

Хөрсний задлан шинжилгээний дүнгээр тухайн бүс нутгуудад тархсан хөрсүүдээс толгодорхог болон талархаг газраар тогтворжсон хөрсний ялзмагт үе давхаргагүй болсон байна. Хөрсний өнгөн үе давхарга авсан дээжний ялзмагийн хэмжээ 3.853% байна. Хөрсний урвалын усан орчин рН 7.27 буюу сул шүлтлэг шинжтэй, карбонатын хэмжээ 0.73%, давсжилт буюу цахилгаан дамжуулах чанар EC 1.171 dS/m байгаа нь давсжилт маш сул илэртэй байна. Хөрсний хөдөлгөөнт фосфорын хэмжээ 100 г хөрсөнд 3.75 мг, калийн хэмжээ 32.4 мг байна.

3.1.6 Ургамлан нөмрөг

Төсөл хэрэгжих Дамбадаржаа дулааны станц нь шигүү суурьшил бүхий гэр хорооллын бүс бөгөөд олон арван жилийн хүний хөл хөдөлгөөний улмаас ургамлын бүлгэмдэл маш хүчтэй нөлөөлөлд өртсөн төлөв байдалтай байна. Өөрөөр хэлбэл хүний үйл ажиллагааны улмаас ургамал бүлгэмдэл антропогений сукцесст орж хуучин байсан уулын хээрийн Хялгана-жигжиг дэгнүүлт үетэн- алаг өвст бүлгэмдэл нь нэг наст Шарилжит бүлгэмдлээр солигдолд орсон байна.

Гэр хороолол хэт их төвлөрсөн, гудамж хоорондох зай талбай бага байхын зэрэгцээ хашаа хоорондох гудамжиндаа авто замын нөлөөгөөр хөрсний эвдрэл ихээр үүссэн, ихэнхдээ ургамалгүй халцгай нүцгэн байна. Гэр хорооллын зарим гудамжны хашааны ёроол хэсгийн нарийхан зурвас газарт алаг цоог ургамалтай байна. Айлуудын хашааны ёроол хэсгийн багахан зурвас хэсэгт армаг тармаг ургасан ширэг Улалж, ямаан Шарилж, ээрэм Шарилж, цагаан Лууль зэрэг хөл газрын ургамлууд бүрхэцийн дийлэнх хувийг бүрдүүлж байлаа.

3.1.7 Ан амьтан

Нийгмийн барилга байгууламжуудыг барих талбай нь хүний хөл хөдөлгөөний эрчим өндөртэй суурьшлын бүсийн төв дунд байрлах ба төслийн талбайд хийсэн ажиглалт, судалгаагаар амьтны төрөл зүйл бүртгэгдээгүй.

3.1.8 Түүх соёлын өв

Төсөл хэрэгжих талбай нь өнөөгийн байдлаар гэр хорооллын суурьшлын бүс бөгөөд төслийн талбайн орчимд түүх, соёлын дурсгалт зүйлс илрээгүй болно.

3.1.9 Тусгай хамгаалалттай газар нутаг

Төслийн талбай нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газартай давхцал байхгүй юм. Тус төслийн талбай нь Богдхан уулын ДЦГ-аас 12 км, Чингэлтэй уулын БНГ-аас 9 км зайд оршдог.

4 ТЭСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн барилгын ажлын үед нийгэм, эдийн засаг, нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийг БОМТ-нд тусгасан болно. “Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ”-г төлөвлөхдөө ажлын үед байгаль орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлон тэдгээрээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээнүүдийг төлөвлөв.

Барилгын материал, техник, тоног төхөөрөмж зэргийг ажлын талбай дээр авчрах, бетоны хольц, хог хаягдлыг тээвэрлэх, ачих буулгах, машин техник, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хөдөлгөх үед ажлын талбайн хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг доройтох, ил задгай барилгын хог хаягдлаар бохирдох, тоос, дуу чимээний бохирдол ихсэх зэрэг түр зуурын нөлөөллүүд үүснэ.

Хүснэгт 4-1 Байгаль орчны бүрэлдэхүүнд тус бүрд үзүүлж болзошгүй нөлөөлөл

№	Үзүүлэлт	Нөлөөллийн түвшин	Тайлбар
1	Газрын хэвлий рельеф	Их	2025 онд шинээр газар шорооны ажил хийгдэх үед тоосжилт үүсээ. Зураг төслийн дагуу газар шорооны ажил хийгдэнэ.
2	Цаг уур, уур амьсгал	Дунд	Цаг агаарын нөхцөл байдлаас ил барилга угсралтын ажиллагаа шууд хамааралтай байдаг бөгөөд цаг уурын таагүй байдлаас барилгын ажил зогсох, удаашрах зэргээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн хугацаа уртасна. Хүчтэй салхи, шороон шуургаар ил задгай барилгын болон ажилчдын хог хаягдал хийсэж орчныг бохирдуулах зэргээр нөлөөлж болзошгүй.
3	Агаарын чанар	Дунд	Барилгын ажил болон техник тоног төхөөрөмжийн хөдөлгөөний үйл ажиллагаанаас тоос шороо үүснэ. Барилгын талбайд ажиллах техникүүдийн түлшний шаталтаас хүлэмжийн хий ялгарна.
4	Усан орчин	Дунд	Төслийн талбайн нөлөөллийн бүсэд гадаргын уст цэг байхгүй, гүний усны түвшинд шүүлийн ус зайлуулах учир барилгын ажил явагдахгүй учраасдунд зэргийн нөлөөлөл үүсгэнэ.
5	Хөрс, газрын гадарга	Их	2025 онд хөрс хуулалт, их газарт явагдана.
6	Ургамал	Дунд	Тухайн газар нь гэр хороолол байсан бөгөөд хөл газрын ургамал ихээр ургасан тул. Ургамлан нөмрөгт нөлөөлөх зүйл бага
7	Амьтан	Нөлөөлөлгүй	Барилгын талбай нь суурин газар учир хүн болон техникийн хөдөлгөөн, дуу чимээ ихтэй тул мэрэгч амьтад болон бор шувууны багийн жижиг шувууд болон синнантроп зүйлүүдээс бусад амьтад ерөнхийдөө дайжсан учир төслөөс амьтанд үзүүлэх шууд нөлөөлөл байхгүй.
8	Дуу чимээ, доргилт, чичиргээ	Дунд	Барилгын материал буулгах, ачих, тээвэрлэлт зэргээс үүсэх дуу чимээ, чичиргээ нь ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.
9	Үнэр	Бага	Ажилчдын кемпийн ахуйн хог хаягдлын цэгийг стандартын дагуу байгуулаагүй, ариун цэврийн байгууламж шаардлага хангахгүй зэргээс тухайн орчин нь үнэр үүсгэж болзошгүй тул барилгын ажлын эхний шатанд төлөвлөлтийг зөв хийх, үйл ажиллагааны турш нөлөөллийг бууруулах ажиллах боломжтой.

5 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЦ БҮРЭЛДЭХҮҮН, НИЙТ ЗАРДАЛ

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, тайлагнах эрх үүргийг төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон Улаанбаатар хотын захиргаа, түүнийг төлөөлөн төслийг өдөр тутмын удирдлагаар ханган ажиллаж буй Төслийн Удирдах Нэгж хүлээх бол БОМТ-д заагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллах үүргийг барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч байгууллагууд хүлээнэ. БОМТ-г хэрэгжүүлэх төсөв зардлыг барилгын ажлын гэрээнд тусган оруулж өгөх бөгөөд гэрээт гүйцэтгэгч байгууллагууд нь барилгын ажлын явцад талбайн байгаль орчны ажилтан авч ажиллуулах үүргийг хүлээнэ.

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал **16сая 430мянга 800 төгрөг** болох бөгөөд зардлын хураангуйг доорх хүснэгтэд ангилан үзүүлэв.

Хүснэгт 5-1. Дамбадаржаа дулааны станц барих төслийн 2025 БОМТ-ний зардлын хураангуй

№	Менежментийн арга хэмжээ	Нийт дүн, төгрөг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	8,288,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	577,200
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,150,000
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2,295,600төгрөг
8	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	3,120,000 төгрөг
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал, төгрөг		16,430,800 (Барилгын ажлын гэрээний үнийн дүнд багтсан)

6 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1 ДАНР гэрээний дугаар бүхий Дамбадаржаа дулааны станц багцад 2025 онд хийгдэх ажил

Төслийн талбайн хэмжээ 24,000 м² буюу 2.4 га байх бөгөөд үүнээс барилгажих талбайн хэмжээ 8595 м² байна

Хүснэгт 6-1. ДАНР багцын 2025 онд хэрэгжүүлэх Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1. Барилгын ажлын үе шат								
1.1. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө								
Газар шорооны ажилд нийт 2.4 газрын гадарга, хэвлий өртөж эвдрэл үүсэх	<ul style="list-style-type: none"> Инженерийн шугам хоолой тавих ажилд өртөж эвдэрсэн 270 м² талбайд талбайд газар шорооны ажил дуусмагц нөхөн сэргээлт, нөхөн дүүргэлт, тэгшилгээний ажлууд хийж, анхны төрх байдалд нь оруулах буюу илүү сайжруулан хэлбэршүүлж, орчны тохижилт үүсгэх Станцын нийт талбайн 10% буюу 2400 м² талбайд ногоон байгууламж үүсгэн тохижуулж, мод зүлэг тарих 	Газар шорооны ажил явагдах бүх цэгт					Барилгын ажил дуусах үед	Нөхөн сэргээлтийн стандарт MNS 5915:2008, MNS 5916:2008, MNS 5917:2008
Газар шорооны ажлаас 2830 м ³ хаягдал шороон материал үүсэх	<ul style="list-style-type: none"> 2089 м³ хэмжээтэй шороон материалыг шуудууны нөхөн дүүргэлтэд ашиглах ба үлдсэн 18,022 м³ хэмжээтэй хаягдал шороон материалыг Цагаан давааны хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэн зайлуулах зөвшөөрлийг Чингэлтэй дүүргийн хот тохижилтын газраас авч, хог хаягдлын гэрээнд тусган оруулж өгнө. Гэрээт гүйцэтгэгч нь хаягдал шороон материалын хэмжээ, овоолго, ачиж зайлуулсан тоо хэмжээний бүртгэлийг өдөр тутам хөтөлж, 7 хоног бүр ТУН-д тайлагнана. 							
Газрын гадаргын төрх байдалд түр хугацааны өөрчлөлт орох	<ul style="list-style-type: none"> Хаягдал шороон материалыг их хэмжээний овоолго үүсгэж хуримтлуулалгүйгээр тухай бүрт нь Цагаандавааны хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэн зайлуулж байх Газар шорооны ажлаас үүсэх шороон материалын овоолгыг үүсгэхдээ орц, гарц, зам талбайг хааж, 	Газар шорооны ажил явагдах бүх цэгт					Газар шорооны ажил явагдах хугацаанд	Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам MNS BS 5906:2018 Барилгын хог хаягдлын менежмент, ашиглалтын дүрэм



2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ: “ДАМБАДАРЖАА ДУЛААНЫ СТАНЦ БАРИХ” ТӨСӨЛ

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	<p>хөдөлгөөнд саад учруулахгүйгээр тооцож байрлалыг сонгох</p> <ul style="list-style-type: none"> Газар шорооны ажил дуусмагц шороон материалын овоолго байрласан цэгт талбайн цэвэрлэгээ, нөхөн сэргээлт хийх 							
1.2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө								
Газар шорооны ажил, талбайн тэгшилгээ хийх, барилгын материал тээвэрлэх, ачиж буулгах зэрэг ажлуудаас тоосжилт үүсч агаар орчныг бохирдуулах	<ul style="list-style-type: none"> Газар шорооны ажил явагдаж буй цэгүүдэд хуурай өдрүүдэд м² талбайд 2-4л нормын дагуу тогтмол усалгааг хийх Хүчтэй салхи шуургатай үед тоосжилтыг багасгах үүднээс ачиж буулгах болон газар шорооны ажлыг түр зогсоох Хаягдал шороон материал, барилгын материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх 	Газар шорооны ажил явагдах бүх цэгт	Усны хэмжээ м ³	1296 ¹	3000 ²	3,888,000	Барилгын ажлын туршид	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн Ерөнхий Шаардлага
Барилгын ажилд ашиглагдах тоног төхөөрөмж, машин механизмаас хийн хаягдал, бохирдуулагч бодисууд агаар орчныг бохирдуулах	<ul style="list-style-type: none"> Барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэгт сар бүр оруулж, утаа их хаядаг, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гаргахгүй байх Тээврийн хэрэгсэл болон хүнд даацын машин механизмын хөдөлгүүрийн тохиргоо, оношлогоо үйлчилгээг тогтмол, чанартай хийх 	Барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизмууд	Барилгын ажлын төсөвт багтсан		Барилгын ажлын төсөвт багтсан		Барилгын ажлын туршид, 7 хоног бүр	MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS 6063-2010 Хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS 4990:2023 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь хорт бодисыг хэмжихэд тавих ерөнхий шаардлага, зөвшөөрөх дээд хэмжээ.
	<ul style="list-style-type: none"> Тээврийн хэрэгслийн утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих аргын стандартын /MNS 5013:2009, MNS5014:2009/ дагуу хянаж зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байлгах 		ОХШХ-т тусган оруулсан		Барилгын ажлын туршид, Сар бүр			

¹ (1.0га*3м³*60хон*3 удаа*2.4 га) = 600 м³- БОАЖЯ сайдын 2015 оны А301 тоот тушаал

² 3000 төг/м³- Гэр хорооллын бүсэд зөөврийн ус түгээх тариф

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Барилгын материал тээвэрлэх, ачиж буулгах зэрэг ажлуудаас орчны агаарт тоосжилт үүсгэх	<ul style="list-style-type: none"> Хаягдал шороон материал, барилгын материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх Хүчтэй салхи шуургатай үед тоосжилтыг багасгах үүднээс хаягдал шороон материал ачих, барилгын материал буулгах зэрэг ажлыг түр зогсоох 	Бүх тээврийн хэрэгсэл		Барилгын ажлын төсөвт багтсан			Барилгын ажлын туршид	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн Ерөнхий Шаардлага
1.3. Физик орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө								
Газар шорооны ажил, зам барилгын ажил, шугам хоолойн угсралтын ажил, барилгын материал тээвэрлэх, ачих, буулгах ажлуудаас дуу чимээ үүсэх	<ul style="list-style-type: none"> Зам барилга ба барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэг, оношлогоо, засварыг сар бүр хийж, хэт их дуу чимээтэй, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гарахыг хориглох Дуу чимээ ихтэй ажлуудыг зөвхөн өглөөний 08:00 цагаас оройн 19:00 цагийн хооронд гүйцэтгэх Дуу чимээний мониторинг хэмжилт хийж хяналт тавих 	Барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизмууд Барилгын ажлын талбай		Барилгын ажлын төсөвт багтсан		ОХШХ-т тусган оруулсан	Барилгын ажлын туршид, Сар бүр	MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага /Гадаад орчны дуу чимээний хүлцэх хэмжээ/ MNS 6768 : 2019. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь шуугианы өртөлтийн хэмжилт, зөвшөөрөх дээд хэмжээ, ажилтны сонсгол хамгаалахад тавих ерөнхий шаардлага
Барилгын болон ахуйн хог хаягдлыг зүй зохистойгоор цуглуулж, зайлуулаагүйгээс физик орчны бохирдол үүсгэх	<ul style="list-style-type: none"> Чингэлтэй дүүргийн тохижилт үйлчилгээний газартай хог хаягдлын гэрээ байгуулж, түүнд хаягдал шороон материал, ахуйн ба барилгын хог хаягдлыг зайлуулах цэг ба тээвэрлэх автомашины улсын дугаарыг тодорхой зааж өгөх Энэхүү тайлангийн 8-р бүлэгт оруулсан Хог Хаягдлын Менежментийн Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах Барилгын түр кэмп тус бүрт хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж, тэмдэгжүүлэх 	Барилгын ажлын талбай, барилгын түр кэмп		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.			Барилгын ажлын туршид	Хог хаягдлын тухай хууль MNS 5344 : 2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам
1.4. Гадаргын ба газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө								



2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ: “ДАМБАДАРЖАА ДУЛААНЫ СТАНЦ БАРИХ” ТӨСӨЛ

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Барилгын ажилд ашиглагдах машин техникүүд Сэлбэ голын усны хамгаалалтын бүсэд зөвшөөрөлгүй нэвтэрч, машин тэргээ угаах зэргээр бохирдол үүсгэж болзошгүй	<ul style="list-style-type: none"> Сэлбэ голын орчимд усны хамгаалалтын бүс тогтоож, тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, Усны тухай хууль"-ийн заалтуудыг дагаж мөрдөх, Сэлбэ голын усны хамгаалалтын бүс рүү барилгын ажилчид нэвтрэх, машин тэрэг угаах, түлш цэнэглэх, хог хаяхыг хатуу хориглох 	Сэлбэ голын усны хамгаалалтын бүс дагуу	Анхааруулах тэмдэг байрлуулах цэгийн тоо	1	100,000	100,000	Барилгын ажлын туршид	Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
Ажилчдын түр кэмпээс үүсэх ахуйн болон барилгын хог хаягдал зэрэг нь хур борооны усаар Сэлбэ гол руу зөөгдөн урсаж бохирдол үүсгэж болзошгүй	<ul style="list-style-type: none"> Барилгын түр кэмпэд хог хаягдлын нэгдсэн цэг тогтоож өгч, хамгаалалтын хашлага хийх Чингэлтэй дүүргийн ТҮК-тэй хог хаягдлыг тээвэрлэх гэрээ байгуулсны үндсэн дээр цугларсан хог хаягдлыг 7 хоногт 2 удаа ачиж зайлуулж байх 	Барилгын түр кэмп, хогийн цэг	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.				Барилгын ажлын туршид	Хог хаягдлын тухай хууль Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
Тос тосолгооны материал санамсаргүй байдлаар асгарч хөрсөнд алдагдан, хур борооны усаар зөөгдөх буюу хөрсөнд нэвчиж, гадаргын усны чанарт дам байдлаар нөлөөлөх болзошгүй	<ul style="list-style-type: none"> Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникт түлш цэнэглэх ажлыг зөвхөн ШТС буюу цементэлсэн талбайд хийж гүйцэтгэх Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникийг ажлын талбарт гарахаас өмнө өдөр бүр үзлэг хийж, тос тосолгооны материал хөрсөнд асгарч алдагдахаас сэргийлэх Шатах тослох материал асгарсан үед, хөрсний бохирдол үүсэхээс сэргийлж синтетик шингээгч материал (TSSW50W) ашиглан шингээж авах 	Барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизмууд	синтетик шингээгч материал (TSSW50W), ширхэг	1	100,000	100,000	Барилгын ажлын туршид	Усны тухайн хууль Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
Барилгын болон ахуйн зориулалтаар багавтар хэмжээний ус ашиглах	<ul style="list-style-type: none"> Үйл ажиллагаанд шаардагдах усны эх үүсвэр, хэрэглээг тогтоож, ус ашиглалтын гэрээ байгуулж ажиллах Ашиглаж буй усны хэмжээ, чанарт хяналт тавьж ажиллах 	Ундны усны эх үүсвэр	тонн	Үйл ажиллагааны зардалд багтсан			Барилгын ажлын явцад улирал бүр	MNS 0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ
Барилгын түр кэмийн үйл ажиллагаанаас үүсэх шингэн хаягдал, 00-д	<ul style="list-style-type: none"> Ажилчдын кэмпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулах 	Барилгын түр кэмп, бүх нэгж хэсгүүд	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.				Барилгын ажлын явцад 7 хоног бүр	Эрүүл ахуйн тухай хууль MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин.

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
хуримтлагдсан ялгадас зэрэг нь хөрсөнд нэвчих, шатах, тослох материал хөрсөнд асгарч улмаар бага гүний уст үеүдийг бохирдуулж болзошгүй	<ul style="list-style-type: none"> Барилгын ажлын явцад ахуйн болон шатах тослох материалуудыг зориулалтын агуулах, талбайд хадгалж ойр орчиндоо хаягдах, асгарах, тархах зэргээр орчноо бохирдуулахаас урьдчилан сэргийлэх хэрэв шатах тослох материал асгарсан үед, тархахаас сэргийлж модны үртэс эсвэл синтетик шингээгч материал (TSSW50W) ашиглан шингээж авах Ажилчдын кэмийн 00-н нүхэнд бактерийн бохирдлоос сэргийлэх био-бэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлораминт цацлагаар тогтмол ариутгаж цэвэрлэж байх 							Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6148:2010 Усны чанар. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Газар шорооны ажлын үед өнгөн хөрсний болон ул хөрсний усны түвшин дээшилж, хөрсний усны шүүрэл үүсэх буюу халиа тошин, хөрс овойлт, суулт зэрэг улирлын цэвдэгтэй холбоотой үзэгдлүүд үүсч болзошгүй	<ul style="list-style-type: none"> Усны барилга байгууламжийн зураг төсөл хийх тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар шүүрлийн усыг зайлуулах дренажийн ажлын зураг төсөл хийлгэх Дренажийн ажил хийх тохиолдолд уг ажлын үед хэрэгжүүлэх Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө боловсруулж, Нийслэлийн БОГ-аар батлуулах бөгөөд уг төлөвлөгөөнд дренажийн ажилтай холбоотойгоор үүсэх байгаль орчны сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, зардал, хугацаа, хамрах хүрээ зэргийг тодорхой зааж оруулсан байна (зөвхөн шаардлагатай тохиолдолд). 	Газар шорооны ажил явагдах цэгүүд		Нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын төсөвт багтсан			Барилгын ажил эхлэхээс өмнө	Усны барилга байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам БНБД 33-01-03 MNS 2990:1980 Хүлцэл суултын нэгдсэн систем. Метрийн эрээс. Үндсэн хэмжээ
1.5. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө								
Машин тэрэг, хүний байнгын хөл хөдөлгөөнөөс үүдэн хөрс суларч доройтох, хөрсний элэгдэл үүсч болзошгүй	<ul style="list-style-type: none"> Хөрсний эвдрэл талхагдал үүсэхээс сэргийлж барилгын материал, хаягдал шороон материал тээвэрлэх хүнд даацын машинуудыг тогтсон маршрутаар зорчуулах 	Барилгын материал тээвэрлэх зам дагуу,		Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан.			Барилгын ажлын туршид	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	<ul style="list-style-type: none"> Станцын талбайн 10%-аас доошгүй хэсэг буюу 2400 м²-аас багагүй талбайд ногоон байгууламж үүсгэж, мод зүлэг тарьж тохижуулах 	Барилгын ажлын нөлөөлөлд өртсөн талбай	Барилгын ажлын дууссаны дараа		Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм, БНБД 30.01.04			

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Газар шорооны ажлаар хуулагдах 2.4 га талбайн өнгөн хөрс стандартын дагуу овоолго үүсгэж хадгалаагүй нөхцөлд хөрсний чанар алдагдаж болзошгүй	<ul style="list-style-type: none"> Дулааны салбар шугам тавих ажилд өртөж эвдэрсэн 270 м² талбайд газар шорооны ажил дуусмагц нөхөн дүүргэлт, нөхөн сэргээлтийн ажил хийх Газар шорооны ажлын үед өнгөн хөрсний овоолгыг тусад нь үүсгэж стандартын дагуу хадгалах ба барилгын ажил дуусах үед нөхөн сэргээлтэд ашиглах 	Газар шорооны ажил явагдах цэгүүд				Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан.		MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт Нөхөн сэргээлтийн стандарт MNS 5915:2008, MNS 5916:2008,
Тос тосолгооны материал санамсаргүй байдлаар асгарч хөрсөнд нэвчсэнээр хөрсөн бүрхэвчийн бохирдол үүсгэж болзошгүй.	<ul style="list-style-type: none"> Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникт түлш цэнэглэх ажлыг зөвхөн ШТС буюу цементэлсэн талбайд хийж гүйцэтгэх Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникийг ажлын талбарт гарахаас өмнө өдөр бүр үзлэг хийж, тос тосолгооны материал хөрсөнд асгарч алдагдахаас сэргийлэх Бетон зуурмаг, асфальт материал тээвэрлэх, буулгах, хучилт хийх ажлуудыг нарийн чанд горимын дагуу тогтоосон талбайн хүрээнд гүйцэтгэж, хөрсөнд асгаралт үүсгэхээс сэргийлэх 	Барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизмууд				Барилгын ажлын төсөвт багтсан	Барилгын ажлын туршид	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Хог хаягдал, кэмпээс гарах бохир ус, бие засах газар, ахуйн бохирдол зэргээс үүдэлтэй хөрсний бохирдол үүсч болзошгүй.	<ul style="list-style-type: none"> Барилгын ба ахуйн хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж тэмдэгжүүлэх Хог хаягдлыг замбараагүй хаях, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглох Барилгын түр кэмпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх Барилгын түр кэмпийн 00-н нүхэнд бактерийн бохирдлоос сэргийлэх био-бэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлораминт цацлагаар тогтмол ариутгаж цэвэрлэж байх 	Барилгын түр кэмпүүд дэхь хогийн цэг, 00-ийн цэг				Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.	Барилгын ажлын туршид	Хог хаягдлын тухай хууль Эрүүл ахуйн тухай хууль MNS 5344 : 2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
1.6. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ								
Хүний замбараагүй үйл ажиллагааны улмаас Сэлбэ голын сав газрын ургамлан нөмрөг талхлагдан бохирдож болзошгүй	<ul style="list-style-type: none"> Сэлбэ голын орчимд усны хамгаалалтын бүс тогтоож, хамгаалалтын бүс рүү барилгын ажилчид нэвтрэх, машин тэрэг угаах, түлш цэнэглэх, хог хаях болон аливаа барилгын үйл ажиллагаа явуулахыг хатуу хориглох 	Барилгын бүх ажилчид				Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө ба энэхүү төлөвлөгөөний 4-р хэсэгт төсөвлөсөн төсвийн дагуу	Барилгын ажлын туршид	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Ургамал хамгааллын тухай хууль



Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1.7. Түүх соёлын өвд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ								
Газар шорооны ажлын явцад газрын хөрсөнд нуугдмал байсан археологи, палеонтологийн санамсаргүй олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрч болзошгүй	<ul style="list-style-type: none"> Санамсаргүй олдвор илэрсэн цэгт барилгын үйл ажиллагааг нэн даруй зогсоох Санамсаргүй олдвор илэрсэн тухай дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх Археологийн хүрээлэнгийн мэргэжлийн баг ажиллуулж шаардлагатай судалгаа шинжилгээ хийлгэх, шаардлагатай бол авран хамгаалах малтлага хийлгэх Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах 	Газар шорооны ажил явагдах бүх цэгт		Барилгын ажлын төсөвт багтсан			Газар шорооны ажлын явцад, тухай бүрт	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
1.8. Нийгэм, олон нийтэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө								
